

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ


/2015 оны 7 сарын 01-ны өдрийн байдлаар/

МАХНЫ ҮНЭ

2015 оны 7 сарын 01-ны өдрийн байдлаар Баруун сайхан, Зүүн сайхан, Хан-уул, худалдааны төвд байрлалтай мах, ногооны захын ханшаар 1 кг хонины мах дунджаар 7200 төгрөгөөр, ямааны мах 6333, адууны мах 6750, тэмээний мах 5500 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонины махны үнэ 800 төгрөгөөр, ямааны махны үнэ 1467 төгрөгөөр тус тус буурчээ. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад махны үнэ 300-500 төгрөгөөр буурсан байна.

Зураг1.Махны үнэ 2015 оны 6-7 сар


Хонины махны үнэ, 1 кг, төгрөгөөр



Адууны махны үнэ, 1 кг, төгрөгөөр




Ямааны махны үнэ, 1 кг, төгрөгөөр



ГУРИЛ, БУДАА, СҮҮ, ЭЛСЭН ЧИХРИЙН ҮНЭ

2015 оны 7 сарын 01-ны өдрийн байдлаар малын шингэн сүү 2500 төгрөг, цагаан будааны үнэ дунджаар 2250 төгрөг, элсэн чихрийн үнэ дунджаар 1933 төгрөг, алтан тариа 1-р гурил 1100 төгрөгөөр худалдаалагдаж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цагаан будааны үнэ 2.3 хувиар өсч, харин алтан тариан гурил 6.1 хувиар, элсэн чихрийн үнэ 3.4 хувиар тус тус буурсан байна. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, гурилын үнэ, 2015 оны 6-7 сар, төгрөгөөр



АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ҮНЭ

2015 оны 7 сарын 01-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээх газруудын мэдээгээр бензин А-80 дунджаар 1650 төгрөг, бензин АИ-92 дунджаар 1890 төгрөг, дизелийн түлш дунджаар 1910 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 3. Авто бензин, дизелийн түлшний үнэ, 2015 он 6-7 сар, төгрөгөөр



ЯМААНЫ НООЛУУРЫН ҮНЭ

2015 оны 7 сарын 01-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй түүхий эдийн захад ямааны цагаан, бор ноолуур дунджаар 54000 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад цагаан, бор ноолуурын үнэ 2000 төгрөгөөр өсчээ.

Зураг 4. Ямааны ноолуурын үнэ, 2015 он 6-7 сар, төгрөгөөр



Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс.